

Аргачлалын тайлбар :

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СЭЗТС-ийн хэлтсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсөвт (аймгийн) төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа.

Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2006 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 194 нэр төрөл болгож 2005 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаар нь ангилахдаа НҮБ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)- ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог тухайн үед амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог жилийн дундаж 18 ба

түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

ХАА-Н САЛБАР

Аймгийн ИТХ-ын 2002 оны ээлжит 8-р хуралдаанаар баталсан бүсүүд:

Баруун бүс : Завхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариалан, Ховд

Хойт бүс : Бөхмөрөн, Давст, Сагил, Түргэн

Зүүн бүс : Зүүнговь, Малчин, Тэс, Хяргас

Өмнөт бүс : Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан

Төвийн бүс: Улаангом хот

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :

... мэдээлэл байхгүй
0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй
Д - дахин

3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцоноор оны эхний 4 сард аймгийн төсөвт 2036.7 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөг 107.7 хувиар биелүүллээ.

Улсын төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 1517.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 1832.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 314.6 сая төгрөгөөр буюу 20.7 хувиар давуулан биелүүллээ.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 1072.2 сая төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 1225.1 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 14.3 хувиар буюу 152.9 сая төгрөгөөр давууллаа. Аймгийн төсөвт 607.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 136.3 хувиар биелүүлж 161.7 сая төгрөгөөр давуулсан байна.

Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймагт төвлөрүүлэх төсвийн орлого 46.1 хувиар буюу 578.4 сая төгрөгөөр илүү, үүнээс аймагт төвлөрүүлсэн орлого 5.8 хувиар буюу 33.2 сая төгрөгөөр, улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлого 80.2 хувиар буюу 545.2 сая төгрөгөөр илүү байна.


2010 оны эхний 4 сард улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогууд нэр төрлөөрөө 3.1 хувиас 3.9 дахин давж биелэгдсэн байна.

Оны эхний 4 сард аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөнөөс орлого тодорхойлох боломжгүй иргэний орлогын төлөвлөгөө 18.2, авто өөрөө явагч хэрэгслэлийн татвар

27.9, үл хөдлөх хөрөнгө, бууны татвар 39.3, газрын төлбөр 10.8, хүү торгуулийн орлого 23.5 хувиар тус тус тасарч байна.



Өнгөрсөн оны мөн үеэс хувиараа аж ахуй эрхлэгч иргэний орлого 36.9, мал бүхий иргэний орлого 50.0, авто өөрөө явагч хэрэгслэлийн татвар 44.9, улсын тэмдэгтийн хураамж 15.0, ашигт малтмалын нөөцийн төлбөр 44.6, рашаан ус ашигласны төлбөр 33.3, хүү торгуулийн орлого 64.9 хувиар тус тус бага байна.

Төсвийн орлогын өсөлт, бууралт, онуудаар




—●— аймгийн төсвийн орлого —■— ОНТ-ийн орлого ба тусламж

Аймгийн төсвийн орлогын 70.2 хувийг тусламжийн орлогоор, 23.3 хувийг орлогын албан татвараар, 0.9 хувийг тусгай зориулалтын орлогын албан татвараар, 0.7 хувийг өмчийн албан татвараар, 3.8 хувийг бусад албан татвараар, 1.1 хувийг татварын бус орлогоор тус тус бүрдүүлсэн байна.



Ноднингийн мөн үетэй харьцуулахад тусламжийн орлогын эзлэх хувь 2.0 пунктээс нэмэгдэж, орлогын албан татварын эзлэх хувь 1.3, татварын бус орлогын эзлэх хувь 0.4 пунктээр тус тус буурсан байна. Аймгийн төсвийн зарлагад орлогын эзлэх хувь 21.3 хувь болсон нь сүүлийн 5 жилийн дунджаас 8.7 пунктээр илүү байна.

Төсвийн зарлагад орлогын эзлэх хувь, хувиар



2005 оны 4 дүгээр сарыг суурь болгон авч жил бүрийн 4 дүгээр сарын эцэстэй харьцуулахад аймаг өөрөө бүрдүүлсэн төсвийн орлого сүүлийн 2 жилд 2005 оны мөн үеэс 3.6 – 5.3 дахин өсч, энэ хугацаанд төсвийн зарлага 3.1 – 3.3 дахин өссөн байна.

Төсвийн орлого, зарлагын өсөлт, 2005 I-IV = 100 %

| | 2005 I-IV | 2006 I-IV | 2007 I-IV | 2008 I-IV | 2009 I-IV | 2010 I-IV |
|---------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| Орлого | 100.0 | 86.7 | 156.9 | 219.3 | 359.7 | 525.6 |
| Зарлага | 100.0 | 118.7 | 164.6 | 247.4 | 314.6 | 330.4 |

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА


Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 8.6 тэрбум төгрөгийг урсгал зардалд зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 5.0 хувиар илүү байна.

Нийт зарлагын 57.1 хувийг цалин хөлсөнд, 6.0 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 30.2 хувийг бусад зардалд, 5.9 хувийг урсгал шилжүүлэгт, 0.9 хувийг хөрөнгө оруулалтанд зориулан зарцуулаа.


Өнгөрсөн оны мөн үеэс цалингийн зардлын эзлэх хувь 1.2 пунктээр, НДШ-ийн зардлын эзлэх хувь 0.1 пунктээр, хөрөнгө оруулалтын зардлын эзлэх хувь 0.3-1.1 пунктээр буурч, бусад зардлын болон урсгал шилжүүлэгийн эзлэх хувь 1.2 пунктээр өссөн байна.

Төсвийн зардлын 21.1 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 54.5 хувийг боловсрол, 20.1 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.9 хувийг нийгмийн даатгал, халамжийн үйл ажиллагаанд, 0.6 хувийг ХАА-н салбарт, 1.8 хувийг ус цаг уур, байгаль орчны үйл ажиллагаанд зориулан зарцуулаа.

2010 оны эхний 4 сар, хувиар



2009 оны эхний 4 сар, хувиар



Ноднингийн мөн үетэй харьцуулахад төрийн үйлчилгээний салбарт зориулсан зардын эзлэх хувь 1.6 пунктээр өсч, эрүүл мэндийн салбарынх 0.5 пунктээр, боловсролын салбарынх 0.3 пунктээр тус тус буурсан байна.

Төсөвт 178 байгууллагуудад 4.5 мянган хүн ажиллаж, ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 6.3 хувиар өссөн байна.



ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА

Аймгийн төсөв 2010 оны 4 дүгээр сард 419.8 сая төгрөгийн өртэй, 87.6 сая төгрөгийн

авлагатай, өнгөрсөн оны мөн үеэс өглөг 372.5 сая төгрөгөөр буюу 8.9 дахин, авлага 17.3 сая төгрөгөөр буюу 24.6 хувиар байна.

4 дүгээр сард 165.0 сая төгрөгийн өр шинээр үүсч, сарын эцэст 47.7 сая төгрөгийн цалингийн, 5.5 сая төгрөгийн НДШ –ийн, 19.3 сая төгрөгийн гэрэл, цахилгааны, 118.9 сая төгрөгийн түлш, халаалтын, 37.1 сая төгрөгийн цэвэр, бохир усны, 25.7 сая төгрөгийн тээвэр шатахууны, 1.2 сая төгрөгийн шуудан холбооны, 6.0 сая төгрөгийн томилолтын, 3.4 сая төгрөгийн хоолны, 20.2 сая төгрөгийн эмийн, 11.1 сая төгрөгийн бусад зардлын өртэй гарсан байна.


2010 оны 4 дүгээр сарын эцэст байгаа өглөг, авлагын хэмжээг сүүлийн 4 жилийн дундажтай харьцуулахад өглөг 12.2 дахин буюу 385.4 сая төгрөгөөр, авлага 31.3 хувиар буюу 66.7 сая төгрөгөөр өссөн байна.



Хэрэглээний үнийн индекс

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 194 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 4 -р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф 2009 оны 12 сараас буюу оны эцсээс 6.6, 2005 оны 12 сар буюу суурь оноос 80.2, 2009 оны 4 сар буюу өнгөрсөн оны мөн үеэс 9.4 хувиар өсч, өмнөх 3-р сараасаа 1.6 хувиар буурсан байна.

Өмнөх 3-р сараас хүнсний барааны бүлгийн үнэ 3.9, орон сууц, ус, цахилгаан түлшний бүлгийн үнэ 0.1, тээврийн бүлгийн үнэ 0.6 хувь буурч, хувцас бөс барааны бүлгийн үнэ 0.8, гэр ахуйн барааны үнэ 0.5, нийтийн хоолны үйлчилгээний үнэ 6.9 өсч бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.



Хүнсний барааны бүлэг дотроос талх гурил будааны дэд бүлгийн үнэ 8.6, сүү сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 11.9, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 12.5 хувь буурч, мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 26.9 хувь өссөн байна.

Өмнөх сараасаа сүү 300, төмс 200, 1, 2, дээд гурилын үнэ тус бүр 100, А-80 бензин 50 төгрөгөөр буурсан нь үнийн ерөнхий индекс буурахад нөлөөлжээ.


Гол нэрийн барааны өсөлт, бууралтын хувь

| | ӨОМҮГ-с | Өмнөх сараас |
|-----------------|---------|--------------|
| цагаан будаа | 14 | 0 |
| хонины мах | 38 | 25 |
| гурил 1-р зэрэг | -13 | -13 |
| сүү | -18 | 18 |
| үзэм | 20 | 0 |
| төмс | 0 | -33 |
| сонгино | 25 | 0 |
| элсэн чихэр | 33 | 0 |
| тараг | 20 | 0 |
| алим | 10 | 0 |
| мандарин | 20 | 0 |
| лууван | 60 | 33 |
| манжин | 25 | 0 |
| байцаа | -20 | 0 |

| | 2010.04/ 2009.12 | 2010.04/ 2009.04 | 2010.04/ 2009.12 | 2010.04/ 2010.03 |
|----------------|------------------|------------------|------------------|------------------|
| ЕРӨНХИЙ ИНДЕКС | 180.2 | 109.4 | 106.6 | 98.4 |

| | 2010.01/ 2009.12 | 2010.02/ 2009.12 | 2010.03/ 2009.12 |
|-----------------------|------------------|------------------|------------------|
| Улсын дундаж индекс | 105.4 | 107.4 | 107.4 |
| аймгийн дундаж индекс | 102.1 | 105.9 | 108.4 |

| | 2010.01/ 2009.12 | 2010.02/ 2010.01 | 2010.03/ 2010.02 |
|-----------------------|------------------|------------------|------------------|
| Улсын дундаж индекс | 103.0 | 102.0 | 102.0 |
| аймгийн дундаж индекс | 102.1 | 103.7 | 102.3 |



1-р сард 2.1 хувийн, 2-р сард 3.7 хувийн, 3-р сард 2.2 хувийн инфляцитай байж, 3-р сард 2 –р сараасаа 1.5 пунктээр буурсан байна. 4-р сарын эцсийн байдлаар өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өмнөх 3 - р сараасаа 2.3 хувиар буурсан байна.



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийг тооцож үзвэл :

| | |
|---|---|
| Хүнсний бараа, ундаа ус 9.0 % | Хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ 9.0 хувь өссөн нь сүү сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 19.7 %, мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 48.7 %, жимс, жимсгэнэний дэд бүлгийн үнэ 13.0 %, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 8.9 хувь, сахарын дэд бүлгийн үнэ 21.1, хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 17.9, согууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 7.6 хувь өссөнтэй холбоотой байна. |
| Сотгууруулах ундаа, тамхи 2.7 % | Сотгууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 % өссөн нь сотгууруулах ундааны дэд бүлгийн үнэ 0.4, тамхины дэд бүлгийн үнэ 8.7 % өссөнтэй холбоотой байна. |
| Хувцас гутал бөс бараа, гутал 21.1 % | Хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ дүнгээрээ 21.1 хувь өссөн нь өвөн бас барааны бүлгийн үнэ 21.7, бүх төрлийн хувцасны дэд бүлгийн үнэ 22.1 % үүнээс эрэгтэй бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 17.7 %, эмэгтэй бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 16.5 %, хүүхдийн бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 38.4, жижиг эдлэл хэрэгслийн дэд бүлгийн үнэ 30.2, гутлын дэд бүлгийн үнэ 20.1 хувь өссөнтэй холбоотой байна. |
| Орон сууц, ус цахилгаан тулш 4.8 % | Орон сууц, тулш цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 4.8 хувь өссөн нь орон сууцны засавар үйлчилгээний дэд бүлгийн үнэ 5.4, усан хангамжийн дэд бүлгийн үнэ 3.3, цахилгаан болон хийн түлшний дэд бүлгийн үнэ 4.6 хувь өссөнтэй холбоотой байна. |
| Гэр ахуйн бараа, тавилга 10.1 % | Гэр ахуйн бараа, тавилганы бүлгийн үнэ дүнгээрээ 10.1 хувь өссөн нь гэрийн тавилганы бүлгийн үнэ 16.7 %, цахилгаан барааны бүлгийн үнэ 14.1 %, гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы барааны бүлгийн үнэ 28.0 %, өвмөл, нэмэн эдлэлийн үнэ 3.0 хувь өссөнтэй холбоотой байна. |
| Эм тариа эмнэлгийн үйлчилгээ -1.8 % | Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.8 % буурсан нь эм тарианы дэд бүлгийн үнэ 4.6 % буурсантай холбоотой байна. |
| Тээвэр -3.3 % | Тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 % буурсан нь хувийн тээврийн хэрэгслийн засавар, үйлчилгээний дэд бүлгийн үнэ 4.6 %, тээврийн үйлчилгээний дэд бүлгийн үнэ 2 хувь буурсантай холбоотой байна. |
| Холбооны үйлчилгээ 22.2 % | Холбооны үйлчилгээний үнэ тариф 22.2 хувь өссөн нь суурин утасны хооронд ярих тариф өссөнтэй холбоотой байна. |
| Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний 8.6 % | Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 8.6 % өссөн нь дур дүрс гэрэл зургийн мэдээллийн хэрэгслийн дэд бүлгийн үнэ 22.4 %, чөлөөт цаг соёлын үйлчилгээний дэд бүлгийн үнэ 1.5 % өссөнтэй холбоотой байна. |
| Боловсролын үйлчилгээ 20.7 % | Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 20.7 % өссөн нь их дээд сургуулийн төлбөр 20.7 хувиар өссөнтэй холбоотой байна. |
| ЗБ нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 14.8 % | Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 14.8 % өссөн нь нийтийн хоолны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 18.2 хувь өссөнтэй холбоотой байна. |
| Бусад бараа үйлчилгээ 4.6 % | Бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 % өссөн нь хувь хүнд хандсан үйлчилгээ 8.2 % өссөнтэй холбоотой байна. |

2010 оны 4 – р сарын 30-ны байдлаар Улаангом хотын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх 3 дугаар сарын дундаж үнэтэй харьцуулахад 10.8 хувь өссөн байна.

Махны дундаж үнэ : 2010 оны 4 дугаар сарын 30-ны байдлаар хонины махны үнэ 3-р сарын дундаж үнээс 26.1 хувь, үхрийн махны үнэ 10, ямааны махны үнэ 54.2 хувь өсчээ.

4 - р сард дунджаар 1 кг хонины мах 3625, үхрийн мах 3575, ямааны мах 2775, 1 л шингэн сүү 1700 төгрөгийн үнэтэй байсан байна.



Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр 6.6 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 39.0 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 38.3 тэрбум төгрөгийг буюу 98.2 хувийг эргүүлэн татсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 2874.0 сая төгрөгөөр буюу 76.0 хувиар, гүйлгээнээс татсан мөнгө 8.7 тэрбум төгрөгөөр буюу 29.3 хувиар, гүйлгээнд гаргасан мөнгө 10.9 тэрбум төгрөгөөр буюу 38.9 хувиар тус тус өссөн байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 27.9 тэрбум төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1.4 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 743.6 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар өсч, хугацаа хэтэрсэн зээл 135.3 сая төгрөгөөр буюу 8.8 хувиар буурсан байна.



1,1 тэрбум төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.9 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 844.0 сая төгрөгөөр буюу 4.4 дахин өссөн байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 16.0 тэрбум төгрөг болж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 45.6 хувиар буюу 5.0 тэрбум төгрөгөөр өсөж, харин оны эцсээс 4.0 хувиар буюу 617.6 сая төгрөгөөр өссөн байна.


Нийт зээлийн 5.0 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байгаа бөгөөд Төрийн банкны нийт зээлийн 3.5, ХААН банк 4.9, Хас банкны 1.7, Хадгаламж банкны 28.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.



Арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэл злэх хувь



Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл сая.т өг




Ажилгүйдэл

Хөдөлмөр зохицуулах албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй эрж буй 1981 ажилгүйдчүүд байгаагийн 47.5 хувь нь буюу 940 эмэгтэйчүүд байна.


Насанд хүрсэн 10.0 мян хүнд 409 ажилгүйдчүүд ноогдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3.2 хувиар өссөн байна.

Оны эхний 4 сарын байдлаар ажилгүйдчүүдийн тоо сүүлийн 4 жилийн дундаас 17.8 хувиар өссөн байна.




Энэ 4-р сард 64 хүн ажилгүйдлэд нэмж бүртгэгдэн ажилгүй байсан хүмүүсээс 288 хүн ажлын байнгын болон түр байраар хангагджээ.

4-р сард ажилгүйдлэд бүртгүүлэгчдийн 1.6 хувь нь орон тооны цомхтголоос, 1.6 хувь нь сургууль төгссөн, 3.1 хувь нь мэргэжлийн ажил олдохгүйгээс, 93.8 хувь нь бусад шалтгаанаар бүртгүүлсэн, ажилд орогчидын 6.9 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 7.3 хувь нь нөхөрлөл, компанид, 85.8 хувь нь бусад газарт ажилд орсон байна.



Ажилгүйдлийн 1.6 хувь нь анх удаа ажил эрж байгаа бөгөөд 58.0 хувь 16-34 насны залуучууд, 20.5 хувь нь дээд, 20.6 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 56.1 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 2.9 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.




Эрүүл мэнд

Энэ оны эхний 4 сард 676 эхээс 678 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 152 оор буюу 18.3 хувиар цөөн байна.

Оны эхний 1-р улиралд улсын дунджаар 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл 23 /Увс 51/, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 29 /Увс 71/, 10000 хүнд ноогдох халдварт өвчний гаралт 28 /Увс 27/ байна.



Гэрийн төрөлт 20 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10 төрөлтөөр нэмэгдсэн байна.



Хүн амын нас баралт 201 гарч 1000 хүнд 2.5 ноогдох болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 13.6 хувиар, 1000 хүнд ноогдох нь 0.3 пунктээр нэмэгдсэн байна.


Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 47 гарч 1000 амьд төрөлтөнд 69.3 ноогдож өнгөрсөн оны мөн үеэс гаралт 18-аар буюу 62.1 хувиар, 1000

амьд төрөлтөнд ноогдох нь 34.4 промилиэр нэмэгдсэн байна.



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Хяргас, Өмнөговь, Улаангом сумдад аймгийн дунджаас 21.7-39.5 промилиэр бага, Бөхмөрөн, Завхан, Зүүнхангай, сумдад гараагүй, бусад сумдад аймгийн дунджаас 7.6 – 1430.7 промилиэр их байна.


0-1 насны хүүхдийн эндэгдэл 35 гарч нялхсын эндэгдлийн түвшин 51.6 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс гаралт 9-өөр, 1000 амьд төрөлтөнд ноогдох эндэгдэл 20.3 промилиэр нэмэгджээ.




Нялхсын эндэгдлийн түвшин Улаангом, Хяргас суманд аймгийн дунджаас бага Завхан, Өмнөговь сумдад гараагүй, бусад сумдад 25.3 – 423.1 промилиэр дээгүүр байна.


Нийт нас баралтын 21.4 хувийг эмнэлгийн нас баралт, үүний 18.6 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Эхийн эндэгдэл 2 буюу Баруунтуруун, Улаангом сумдад гарч, осол гэмтлийн улмаас 23, хорт хавдрын улмаас 47 хүн нас баржээ.






Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 337 болж өнгөрсөн оны мөн үеэс 30.4 хувь буюу 147 гаралтаар буурсан байна.




10000 хүн тутмаас 43 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд энэ үзүүлэлт Өмнөговь суманд /45/, Улаангом / 99.6 / суманд аймгийн дунджаас дээгүүр, Өндөрхангай суманд гараагүй бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна.





Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 13.6 хувь нь гепатит, 30.0 хувь нь БЗХӨ, 7.7 хувь нь сүрьеэгээр, 3.0 хувь нь мөөгөнцрөөр, 16.9 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилжээ.



Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд 2009 - 4 сар



Өнгөрсөн оны мөн үеэс сүрьеэ 6, хүйтэн 28, трихоманиаз 13, гахай хавдар 97 гаралтаар нэмэгдэж, гепатит 53, бруцеллэз 4, мөөгөнцөр 8, тэмбүү 2, салхинцэцэг 139, цусан суулга 2 гаралтаар буурч, мэнэн, гар хөл амны өвчин, суулгалт халдвар, улаанууд, гар хөл амны өвчнүүд гараагүй байна.



Амбулаториор 122.4 мянган хүнд үзлэг хийгдэж, 7.4 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амбулаториор үйлчлүүлсэн хүний тоо

1.8 хувиар бага, хэвтэн эмчлүүлэгчид 4.2 хувиар илүү байна.

Хувийн хэвшлийн 10 эмнэлгээр 1.6 мянган хүн үзлэг, эмчилгээ, оношлогоо хийлгэж 11.5 сая төгрөгийн орлоготой ажилласныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үйлчлүүлсэн хүн 0.5 мянгаар, орлого нь 5.3 сая төгрөгөөр бага байна.

Дотоод худалдаа

| | Мэдээлэлд хамрагдсан ААН, иргэдийн тоо | борлуулалтын орлого /сая.төг/ | нийт бүтээгдэхүүний өртөг сая.төг | | ажиллагсдын тоо хүн | Нэг нэгжийн сарын дундаж борлуулалтын орлого /сая.төг/ |
|-----------------|--|-------------------------------|-----------------------------------|----------------|---------------------|--|
| | | | бүгд | үүнээс эмэгтэй | | |
| 2010-1-р улирал | 40 | 2454.4 | 2207.6 | 179 | 68 | 20.5 |
| 2009-1-р улирал | 44 | 2376.8 | 2034.9 | 187 | 71.0 | 18.0 |

Худалдааны салбарын мэдээний түүвэрт хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагууд 2454.4 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 77.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нэг нэгж дунджаар сард 20.5 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Энэ нь өнгөрсөн оноос 1.5 сая төгрөгөөр илүү байна.


Хөдөө аж ахуй

Том малын зүй бусын хорогдол

Оны эхний малын 20.4 хувь буюу 473.1 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оноос 3.2 дахин буюу 325.8 мянган толгойгоор илүү байна.

Нийт хорогдлын 3.2 хувийг өвчний хорогдол эзэлж байна. 128.7 мянган хээлтэгч мал хорогдсон нь том малын зүй бус хорогдлын 27.2 хувийг эзэлж байна.

Нийт хорогдлын 49.5 хувийг хонь, 44.5 хувийг ямаа, 3.8 хувийг үхэр, 2.1 хувийг адуу, 0.1 хувийг тэмээний хорогдол эзэлж байна.



ямаа, хонины үнэ өмнөх сартай харьцуулахад 5.6 – 53.3 мянган төгрөгөөр өсч, бүх насны үхрийн үнэ 6.0 – 78.0 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

ХАА - н зарим бүтээгдэхүүн:

Гол нэрийн бүтээгдэхүүн болох ноолуур 47750 , тэмээний шир 10000 , хонины арьс 500, хонь ба үхрийн мах 4000, тэмээний мах 2800, сүү 1700, тэмээний ноос 2500, ямааны арьс 9000 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Мал, амьтны гаралтай зарим түүхий эдийн үнийг өмнөх сартай харьцуулахад тэмээний ноос, хонь ба үхрийн махны үнэ 1000 төгрөг, ноолуур 9750 төгрөгөөр тус тус өсч, харин ямааны арьсны үнэ 1500 төгрөгөөр буурчээ.

Газар тариалан болон бусад бүтээгдэхүүн :

Улаан буудай 550.0 мянга, боодолтой өвс 5500, түлээний мод 22312 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Өмнөх сартай харьцуулахад улаан буудай 50.0 мянга, түлээний мод 188 төгрөгөөр тус тус буурч, боодолтой өвс 1125 төгрөгөөр өсчээ.




Төллөлт, төл бойжилт

Оны эхний эхийн 47.8 хувь буюу 515.6 мянган эх мал төллөж, гарсан төлийн 57.5 хувь буюу 296.3 мянган төл бойжиж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бойжилтын хувь 22.5 пунктээр, төллөлтийн хувь 21.3 пунктээр тус тус бага, харин төлийн хорогдол 60.9 мянгаар өссөн байна.

Завхан, Өмнөговь, Улаангом, Зүүнхангай, Өлгий, Тэс, Өндөрхангай, Тариалан, Түргэн сумдын төллөх насны эхийн 8.8 – 45.4 хувь нь төллөсөн нь аймгийн дунджаас 2.4 – 39.0 пунктээр бага байна.

Нийт 219.9 мянган төл хорогдсоны 99.1 хувийг хурга, ишигний хорогдол эзэлж байна. Малчин, Ховд, Хяргас, Бөхмөрөн, Наранбулаг, Өмнөговь, Өлгий, Өндөрхангай, Баруунтуруун Зүүнговь, Зүүнхангай сумдууд төлийн хорогдол ихтэй, гарсан төлийн 22.5 – 55.0 хувийг бойжуулж байгаа нь аймгийн дунджаас 2.5 – 35.0 пунктээр бага байна.



Түргэн, Наранбулаг, Өндөрхангай, Завхан, Өлгий, Тариалан, Өмнөговь, Зүүнхангай, Баруунтуруун, Зүүнговь сумдын оны эхний малын 21.8 – 51.7 хувь нь хорогдож аймгийн дунджаас 1.4 – 31.3 пунктээр их, бусад сумдын оны эхний малын 5.7 – 20.3 хувь хорогдсон нь аймгийн дунджаас 0.1 – 14.7 пунктээр бага байна.

Зүүнговь сумын оны эхний малын 51.7 хувь, Баруунтуруун сумын 48.1 хувь, Зүүнхангай сумын 36.5 хувь, Өмнөговь сумын 30.4 хувь, Өлгий сумын 26.1 хувь, Тариалан сумын 24.1 хувь нь хорогдсон нь хамгийн өндөр хорогдолтой сумдын тоонд орж байна.

Манай аймагт 1960 оны зуданд оны эхний малын 11.5 хувь буюу 162.2 мянган толгой мал, 1966 онд оны эхний малын 17.2 хувь буюу 274.1 мянган мал, 2000 онд оны эхний малын 15.2 хувь буюу 286.8 мянган мал тус тус хорогдож байсан байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ




2009 оны 9 дүгээр сараас эхлэн хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн болох 119 нэрийн бүтээгдэхүүний үнийг бүх сумдаас цуглуулан авч аймгийн дундаж үнэ тооцож байна. Бүтээгдэхүүний нэр, төрлийг нилээд задалж ангилсан учир өнгөрсөн жилүүдтэй харьцуулах боломжгүй тул өмнөх сартай харьцуулж танилцууллаа.

Малын үнэ 2010 оны 4-р сарын 28-ны байдлаар аймагт нас гүйцсэн ат ба ингэ 350 – 385.0 мянга, өсвөр болон нас гүйцсэн адуу 150.0 – 300.0 мянга, өсвөр насны болон нас гүйцсэн эм ба эр үхэр 160.0 – 220.0 мянга, өсвөр насны төлөг, нас гүйцсэн эр ба эм хонь 30.6 – 69.8 мянга, өсвөр насны борлон, нас гүйцсэн эр ба эм ямаа, ухна 17.5 – 40.0 мянган төгрөгний дундаж үнэтэй байна.

Аймгийн дунджаас Улаангом суманд нас гүйцсэн тэмээ 50.0 – 65.0 мянга, Сагил, Ховд суманд нас гүйцсэн морь, гүүний үнэ 15.0 – 50.0 мянга, Тэс, Давст, Өндөрхангай, Түргэн, Наранбулаг, Улаангом, Сагил суманд нас гүйцсэн эр хонины үнэ 5.2 – 20.2 мянга, Тэс, Наранбулаг, Улаангом , Давст суманд нас гүйцсэн эр ямааны үнэ 0.5 – 10.2 мянган төгрөгөөр тус тус илүү ханштай байна.

4 дугаар сарын 28 - ны байдлаар бүх насны адуу, эр ба эм






АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1.5 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 18.9 хувиар буюу 246.2 сая төгрөгөөр өслөө.



Нийт үйлдвэрлэлтийн 53.5 хувийг хүнс ундааны үйлдвэрлэл, 29.6 хувийг эрчим хүч түгээлт, 9.9 хувийг нүүрс олборлолт, 5.0 хувийг бусад боловсруулах үйлдвэрлэл, 1.2 хувийг усан хангамж, 0.7 хувийг хувцас үйлдвэрлэл эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтэц хувиар, 2010 оны 04 сар



Өнгөрсөн оны мөн үеэс /зэрэгцүүлэх үнээр тооцсоноор/ нүүрс олборлолт 76.4, эрчим хүч түгээлт 19.0, хүнс ундааны үйлдвэрлэл 14.9, хувцас үйлдвэрлэл 9.5 хувиар өсч, бусад боловсруулах үйлдвэрлэл /өлөн,шевро,булигар, хөх шир/ 7.5, усан хангамж 3.3 хувиар тус тус буурсан байна.

Оны үнээр 2.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 2.7тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс борлуулалтын орлого 29.8 хувиар өслөө. Нийт борлуулалтын


4.1 хувь буюу 114.0 сая төгрөгийн боловсруулсан өлөн гэдэс болон нүүрс гадаадад экспортолсон байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбарт эзлэх хувцас үйлдвэрлэл 0.1, нүүрс олборлолт 2.3 эрчим хүч түгээлт 2.7 пунктээр өсч, хүнс ундааны үйлдвэрлэлтийн хувь 4.2, бусад боловсруулах үйлдвэрлэл 1.0 пунктээр буурч, усан хангамж өнгөрсөн оны түвшинд байна.



Салбарын бүтэц

| | 2008 I-Y | 2009 I-Y | 2010 I-Y |
|-------------------------------|----------|----------|----------|
| Цахилгаан дулаан түгээлт | 32.7 | 26.9 | 29.6 |
| Нүүрс олборлолт | 10 | 7.6 | 9.9 |
| Бусад ашигт малтмал олборлолт | 0 | 0 | 0 |
| Хүнс ундаа үйлдвэрлэлт | 50.1 | 57.7 | 53.5 |
| Хувцас үйлдвэрлэлт | 0.2 | 0.6 | 0.7 |
| Мод модон бүт үйлдвэрлэлт | 0 | 0 | 0 |
| Бусад боловсруулах аж үйлдвэр | 5.6 | 6 | 5.0 |
| Усан хангамж | 1.4 | 1.2 | 1.2 |
| Дүн | 100.0 | 100.0 | 100.0 |


2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцсоноор суурь он буюу 2005 оноос боловсруулах үйлдвэрлэл 15.6, уул уурхай олборлолтын салбар 7.9, эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 4.5 дахин өссөн байна.



Аж үйлдвэрийн салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 2005 оны мөн үетэй харьцуулбал өлөн 25.1, архи 18.9 ундаа 5.3, нарийн боов 4.1, нүүрс 7.9, дулаан 5.2, түгээсэн цэвэр ус 4.1 дахин өсчээ.



2005 оноос импортын цахилгаан 41.1, цахилгааны хэрэглээ 38.1 хувиар өссөн байна.






Аж үйлдвэрийн чиглэлийн аж ахуйн нэгжүүд 27 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гол нэр төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч 6 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, өнгөрсөн оны түвшинд 3 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдсэн байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс хүнсний давс 7.4, сироп 4.3, варень 3.0, нүүрс 2.1, эмэгтэй хослол 2.0, д, хэрчсэн гурил 86.3, гутал 78.7, ундаа 72.4, нарийн боов 21.8, дээл 13.7, дулаан 19.0, чацарганы тос 18.7, талх 12.9, архи 11.4 хувиар өсч, чацарганы шүүс 56.9, булигар 50.0, витамин жүүс 47.9, өлөн 9.6, шевро 33.3, ундаа 11.4, цэвэр ус 3.3, хувиар тус тус буурсан байна.

Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт /Биег хэмжээгээр/


| | 2006 I-Y | 2007 I-Y | 2008 I-Y | 2009 I-Y | 2010 I-Y | |
|-------------|----------|----------|----------|----------|----------|-------|
| Нүүрс | ТН | 12.6 | 10.8 | 16.6 | 11.8 | 24.7 |
| Архи | МНЛ | 119.8 | 212.1 | 134.8 | 159.4 | 177.6 |
| Ундаа | МНЛ | 32.9 | 11.5 | 18.4 | 19.5 | 15 |
| Нарийн боов | ТН | 33.9 | 103.6 | 71.2 | 59.5 | 72.5 |
| Өлөн | МНГТ | 20.4 | 27.5 | 67.8 | 69.5 | 62.8 |



Гэмт хэрэг

Оны эхний 4 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 132 болж өнгөрсөн оны мөн үеэс 14.8 хувиар, сүүлийн 4 жилийн дунджаас 2.9 хувиар тус тус өсч, гэмт хэрэгт холбогдогч 136 болж өнгөрсөн оны мөн үеэс 12.4 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 4 сараар




Гэмт хэрэгт холбогдогчдоос 3.6 хувь буюу 5 эмэгтэй, мөн 1.5 хувь буюу 2 хүүхэд байгаа

бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хэрэгт холбогдогч эмэгтэйчүүдийн тоо 37.5 хувиар, хүүхдүүдийн тоо 60.0 хувиар тус тус буурсан байна. Гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 79.7 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 65.9 хувиар буурсан байна. Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 15.9 хувь нь бүлэглэж үйлдсэн, 25.7 хувь нь согтуугаар үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүлэглэсэн хэрэг 8.4 пунктээр буурч, харин согтуугаар үйлдсэн хэрэг 10.3 пунктээр буюу гаралтын тоо 1.8 дахин өссөн байна. Гэмт хэргийн өнгөрөвч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2.9 хувиар, үүний дотроос иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг 3.4 хувиар тус тус өсч, харин бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 25.0 хувиар буурсан байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 11.7 хувиар, үүний дотроос нийт хулгайн гэмт хэрэг 20.4 хувиар буурсны дотор иргэдийн өмчийн хулгайн хэрэг 40.0 хувиар, малын хулгай 33.6 хувиар, Завших, үрэгдүүлэх гэмт хэрэг 85.7 хувиар тус тус буурсан бөгөөд бусад хулгайн гэмт хэрэг 8 дахин, бусад өмчлөх эрхийн гэмт хэрэг 3 дахин тус тус өссөн байна. Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7 дахин, хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 2 дахин, тээврийн хэрэгслэлийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг хэрэг 66.7 хувиар, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 111.1 хувиар, захиргааны журмын эсрэг гэмт хэрэг 5 дахин тус тус өссөн бөгөөд өнгөрсөн оны 4 сард гарч байгаагүй хүнийг санаатай алах гэмт хэрэг, булаалтын гэмт хэрэг 1-2 тохиолдол гарсан байна.

хэргийн дийлэнх хувийг / 29.5 / нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Шүүхээр 46 гэмт хэрэгт 68 хүн ял шийтгүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс шийдүүлсэн гэмт хэрэг 44.6 хувиар, шийтгүүлсэн хүний тоо 54.1 хувиар тус тус буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

2010 оны 4-р сард агаарын дундаж температур Баруунтуруун, Зүүнговь, Тэс, Малчин, Өндөрхангай -4.6-ээс -6.0 хэм хүйтэн, хөрсний дундаж температур Өмнөговь, Зүүнговь, Өндөрхангай, Малчин, сумдад -2.6 ээс -5.6 хэм хүйтэн байлаа.

10 м/сек –ээс их салхитай өдөр Өмнөговьд 14, Завханд 14, Зүүнговьд 11, Зүүнхангайд 27, Наранбулагт 20 хоног байв.


Баруунтуруунд 4, Малчинд 4, Зүүнхангайд 6, Улаангомд 5, Өмнөговьд 5 хоног тундастай байж нийлбэрээрээ Өндөрхангайд 4.0 мм, Малчинд 2.5 мм, Зүүнхангайд 2.3 мм, Түргэнд 2.6 мм тундас орсон нь аймгийн хэмжээнд хамгийн их тундастай сумдууд болж байна.

Цасны зузаан Баруунтуруун 26 см, Малчин 22 см, Давст 22 см, Зүүнговь 25 см, Тэс 25 см, Хяргас 28 см, Сагил 22 см, Түргэн 16 см байгаа нь бусад сумдаас харьцангуй илүү байна.

АЙМГИЙН

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.ЭРДЭНЭСҮРЭН



Нийт гэмт хэргийн 49.2 хувь нь Улаангом суманд үйлдэгдсэн ба үйлдэгдсэн нийт